



ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

“Дулаан шарын гол” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2022 оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн тайланг танилцуулах тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

... Компанийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл 100 хувь биелж 382.3 сая төгрөгийн худалдан авалт хийжээ. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд хийсэн дотоод хяналтын тайланг сонсож танилцав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан тухай танилцуулав.... гэжээ.



ДАРГА

П.ДАВААДОРЖ



**ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны
ажлын төлөвлөгөөг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн а/4905 дугаар удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг гүйцэтгэх захирал /Б.Батхуяг/, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Н.Алтанзул/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



П.ДАВААДОРЖ

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 01 дүгээр сарын 05-ны
өдрийн 24 дугаар тогтоолын хавсралт



**“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах эзэн
1	Компанийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний тухай	1 дүгээр сар	Дэд захирал
2	Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг батлах тухай		Эдийн засагч
3	Компанийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тухай танилцуулах		Дэд захирал
4	Компанийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын дүн танилцуулах, үндсэн хөрөнгө актлах санал, элэгдэл нь дууссан хөрөнгийг дахин үнэлэх тухай	2 дугаар сар	Ерөнхий нягтлан бодогч
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайланг хэлэлцэх		Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга
6	Компанийн дотоод хяналтын нэгжийн 2022 оны ажлын тайланг танилцуулах тухай		Дотоод хяналтын ажилтан
7	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хорооны 2022 оны ажлын тайлангийн тухай		Дэд хорооны дарга нар
8	Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооноос 2022 онд хийсэн ажлын тайлан, компанийн санхүүгийн тайлан тэнцэлд өгөх дүгнэлт	3 дугаар сар	Аудитын хорооны дарга
9	Компанийн 2022 оны үйл ажилгааны тайлан, Хөрөнгө оруулалт, Их засвар, ТЗБАХ-ний төлөвлөгөөний гүйцэтгэл		Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер, Ерөнхий нягтлан бодогч

10	Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлт		Ерөнхий нягтлан бодогч, Эдийн засагч
11	Компанийн 2022 оны зорилтод түвшингийн төлөвлөгөөний болон гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын гэрээний биелэлт, контрактын гэрээг дүгнэх тухай		Гүйцэтгэх захирал
12	Ногдол ашгийн тухай		Ерөнхий нягтлан бодогч
13	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тов тогтоох тухай		ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
14	Нэр дэвшүүлэх түр хороо байгуулах тухай		ТУЗ-ийн дарга
15	Компанийн гүйцэтгэх захиралтай контракт байгуулах тухай	4 дүгээр сар	ТУЗ-ийн дарга
16	Компанийн 2023 оны I улирлын санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлтийн тухай	5 дугаар сар	Эдийн засагч
17	Аудитын зөвлөмжөөр хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэл		Ерөнхий нягтлан бодогч
18	Компанийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийн хагас жилийн тооллогын дүнгийн тухай	8 дугаар сар	Ерөнхий нягтлан бодогч
19	Компанийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшингийн биелэлт, аудитаас өгсөн зөвлөмжийн биелэлтийн тухай		Ерөнхий нягтлан бодогч, Эдийн засагч
20	Компанийн 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ-ний ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тухай		Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер
21	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооноос компанийн 2023 оны II улирлын тайлан тэнцэлд өгөх дүгнэлтийн тухай		Аудитын хорооны дарга

22	Компанийн үйл ажиллагаатай танилцах, ажилтнуудтай уулзалт зохион байгуулах		ТУЗ-ийн дарга, гишүүд
23	Компанийн 2023 оны хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ-ний ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл, өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын тухай	9 дүгээр сар	Ерөнхий инженер
24	Компанийн 2023 оны III улирлын санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлтийн тухай	10 дугаар сар	Ерөнхий нягтлан бодогч, Эдийн засагч
25	Компанийн 2024 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төслийг хэлэлцэх тухай		Ерөнхий нягтлан бодогч, Эдийн засагч
26	Арилжааны банкуудтай байгуулсан цалингийн санхүүжилтийн овердрафтын зээлийн эрх нээх гэрээний хугацааг сунгах тухай	11 дүгээр сар	Ерөнхий нягтлан бодогч
27	Компанийн 2023 оны худалдан авалтын тайлан		Гүйцэтгэх захирал
28	Аудитын зөвлөмжөөр хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэлийн тухай		Ерөнхий нягтлан бодогч
29	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн тухай	12 дугаар сар	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
30	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөг батлах тухай		ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
31	Компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тодотгол хийх тухай		Ерөнхий нягтлан бодогч, Эдийн засагч
32	Компанийн 2023 оны худалдан авалтын төлөвлөгөөнд тодотгол хийх	Тухай бүр	Гүйцэтгэх захирал
33	Цаг үеийн тулгамдсан бусад асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх		Холбогдох ажилтнууд